



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/143.

Улаанбаатар хот

Үндэсний сурын харваачдад  
цол олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 11 дүгээр зүйлийн 11,3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар Төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 34 жилийн ойн их баяр наадмын Үндэсний халх сурын эрэгтэй харваанд түрүүлсэн Лхагвагийн Батболдод “АЙМГИЙН МЭРГЭН” цол, хоёрдугаар байр эзэлсэн спортын дэд мастер Гэрэлчулууны Сугар-Эрдэнэд “АЙМГИЙН ГАРАМГАЙ ХАРВААЧ” цол, дөрөвдүгээр байр эзэлсэн хоёр дугаар зэргийн харваач Даш-өлзийгийн Алтаншагайд “АЙМГИЙН ОНЧ ХАРВААЧ” цол, тавдугаар байр эзэлсэн спортын дэд мастер Содвонжамцийн Мягмаржавт “АЙМГИЙН ТОД ХАРВААЧ” цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД